



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/53

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.15, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, 65 дугаар зүйлийн 65.1, 65.1.1, Сангийн сайдын 2012 орны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалт нийтлэг журам"-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Билгийн тооллын цагаан сарын баярыг тохиолдуулан аймгийн Засаг даргаар ажиллаж байсан дарга нар, аймгийн Засаг даргын Тамгын газрын ахмадууд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, Тамгын газрын албан хаагчдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэхэд зориулж 4101100 төгрөгний хөрөнгө зарцуулсугай.

Хоёр. Дээрх зардлын 4101100 /дөрвөн сая нэг зуун нэг мянга нэг зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хэнтий Нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ /Г.Баяржаргал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 357

